

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/01/НА/СТА-ТЕЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Болормаа  
Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.04.19 № 95  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ  
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төслийн зээлийн төлбөрт өмнөх онд 13,621.4 сая төгрөг, тайлант онд 1,225.9 сая төгрөг, нийт 14,842.1 сая төгрөгийг Сангийн яам суутган тооцсон боловч төслийн гүйцэтгэл 98%-тай, улсын комисс хүлээж аваагүй, өмчлөгчийн асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй, нийт зээлийн ер төлбөрийн дүн тодорхойгүй тул урьдчилж гарсан зардлаар тайлагнасаар байна.

### Аудитын гол асуудал

Өмнөх оны Орхон аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлаас 25 төрийн болон төрийн бус байгууллагын 200 гаруй ажилтны цалингийн санхүүжилтэд 2,498.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийг үр ашигтай удирдаж, санхүүгийн сахилга батыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлаагүй тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн. Мөн авлагын данстай холбоотой 2, үндсэн

хөрөнгийн данстай холбоотой 1, өр төлбөрийн данстай холбоотой 2, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1, нийт 5 зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, илэрсэн зөрчил дахин давтагдаж тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн Засаг даргын Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийг 98.6 хувьтай биелүүлж ажилласан байна.

Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 14 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс, гүйцэтгэлээр 2 төсөл арга хэмжээний биелэлт 70-80 хувьтай, нийт гүйцэтгэлийг 96.4 хувьтай гэж үнэлжээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг 91.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



# 1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,268,157.2	105,179,673.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,516,009.1	55,645,600.0
33	АВЛАГА	20,091,134.7	22,454,901.5
34	УРЬДЧИЛГАА	13,621,448.8	14,842,127.4
35	БАРАА МАТЕРИАЛ	5,949,684.6	12,187,484.1
36	НӨӨЦИЙН БАРАА	89,880.0	49,560.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	234,736,895.7	284,401,929.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000.0	100,000.0
37200	Үнэт цаас	100,000.0	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	234,636,895.7	284,301,929.5
39200	Биет хөрөнгө	224,666,068.2	273,286,395.0
39300	Биет бус хөрөнгө	9,970,827.6	11,015,534.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>318,005,052.9</b>	<b>389,581,602.6</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,511,226.8	32,716,381.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,146,856.3	25,633,489.9
41300	Өглөг	22,947,902.2	24,008,810.2
41400	Урьдчилж орсон орлого	2,198,954.1	1,624,679.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,364,370.5	7,082,891.8
42200	Урт хугацаат зээл	6,364,370.5	7,082,891.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	286,493,826.2	356,865,220.9
51	Засгийн газрын хувь оролцоо	286,493,826.2	356,865,220.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	17,176,568.0	16,845,008.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,068,468.6	26,181,818.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	58,737,174.8	64,822,824.7
51200	Хуримтлагдсан үр дүн	172,270,033.3	233,817,852.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,241,581.5	15,197,717.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>318,005,052.9</b>	<b>389,581,602.6</b>

## 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	251,016,915.2	354,134,609.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	197,206,303.0	257,455,381.9
110	Орлогын албан татвар	147,234,680.7	202,406,053.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	56,900,096.7	68,039,751.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-3,802,030.5	-4,484,320.1
1103	ААН-ын орлогын албан татвар	94,136,614.5	138,850,622.5
113	Хөрөнгийн албан татвар	23,729,027.6	21,379,837.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,242,594.7	33,669,490.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,352,234.9	73,638,316.3

120	Нийтлэг татварын бус орлого	23,457,171.7	49,823,218.0
121	Хөрөнгийн орлого	0.0	4,432,825.0
122	Тусламжийн орлого	58,811.9	2,600,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,836,251.3	16,782,273.3
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>20,458,377.2</b>	<b>23,040,911.3</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>157,716,113.0</b>	<b>252,218,392.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>157,716,113.0</b>	<b>252,218,392.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>63,898,848.5</b>	<b>84,643,859.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,947,511.7	15,455,524.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,288,513.9	1,845,512.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,604,324.2	917,062.7
2104	Хангамж, бараа материалын зардал	3,885,979.7	5,833,110.1
2105	Нормативт зардал	148,347.0	214,398.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,401,952.0	1,546,502.3
2107	Томилолт, зочны зардал	74,225.4	192,440.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,202,968.6	33,362,861.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,345,026.1	25,276,446.2
211	ХҮҮ	0.0	235,531.5
212	ТАТААС	1,182,752.2	1,217,712.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,634,512.3	166,121,289.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>93,300,802.2</b>	<b>101,916,217.3</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>456,181.9</b>	<b>521,312.0</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>174,943,471.5</b>	<b>40,845,755.7</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-81,186,487.4</b>	<b>61,591,773.6</b>

### 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	249,566,868.3	344,639,046.0
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	174,943,408.7	257,455,381.9
<b>110</b>	Орлогын албан татвар	124,971,786.4	202,406,053.8
<b>1100</b>	Хувь хүний орлогын албан татвар	56,900,096.7	68,039,751.4
<b>1101</b>	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-3,802,030.5	-4,484,320.1
<b>1103</b>	ААН-ын орлогын албан татвар	71,873,720.2	138,850,622.5
<b>113</b>	Хөрөнгийн албан татвар	23,732,242.0	21,379,837.5
<b>118</b>	Бусад татвар, төлбөр, хураамж	26,239,380.2	33,669,490.5
<b>1180</b>	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,674,431.5	3,138,021.0
<b>1181</b>	Газрын төлбөр	23,216,125.1	30,005,843.4
<b>1182</b>	Байгалийн нөөц ашигласны төлбөр	348,823.6	525,626.1
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	52,551,896.0	62,449,232.8
<b>120</b>	Нийтлэг татварын бус орлого	42,715,644.7	38,634,134.6
<b>121</b>	Хөрөнгийн орлого	0.0	4,432,825.0

122	Тусламжийн орлого	0.0	2,600,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	9,836,251.3	16,782,273.3
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	22,071,563.6	24,734,431.4
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	173,727,824.6	258,821,469.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	173,727,824.6	258,821,469.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	78,333,926.7	88,030,191.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,671,277.9	21,154,566.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,652,385.8	2,869,203.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,278,723.2	1,762,523.3
2104	Хангамж, бараа материалын зардал	4,435,373.5	5,773,075.3
2105	Нормативт зардал	193,849.8	207,427.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,442,587.6	1,435,253.3
2107	Томилолт, зочны зардал	74,225.4	192,440.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,361,100.4	39,049,376.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,224,403.2	15,586,324.0
211	<b>ХҮҮ</b>		1,461,460.1
212	<b>ТАТААС</b>	1,182,752.2	1,217,712.2
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	94,211,145.7	168,112,105.6
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	75,839,043.7	85,817,576.8
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	20,674.4	20,036.7
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	65,403,713.7	73,513,197.9
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	65,403,713.7	73,513,197.9
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	65,403,713.7	73,513,197.9
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-65,383,039.3	-73,493,161.2
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-136,653.6	-194,824.7
14	<b>Бусад эх үүсвэр</b>	475,446.4	483,575.3
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	383,100.0	513,400.0
25	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	229,000.0	165,000.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	10,319,350.8	12,129,591.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,196,658.3	43,516,009.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,516,009.1	55,645,600.0

#### 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,242,721.4	344,242,721.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	49,553.4	49,553.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,292,274.8	344,292,274.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-35,851.2	-35,851.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	36,120.0	36,120.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	23,387,769.9	23,387,769.9
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-81,186,487.4	-81,186,487.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	286,493,826.2	286,493,826.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	286,493,826.2	286,493,826.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-43,954.8	-43,954.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	286,449,871.4	286,449,871.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-43,864.0	-43,864.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	637,247.0	637,247.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	8,230,192.9	8,230,192.9
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	61,591,773.6	61,591,773.6
20	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	356,865,220.9	356,865,220.9

#### 1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт хэмнэлт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	307,911,751.7	273,372,833.7	34,538,918.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,944,368.1	213,213,274.0	7,731,094.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,360,816.7	46,222,808.9	7,138,007.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,611,760.4	15,172,357.3	439,403.14
210101	Үндсэн цалин	8,521,503.2	8,124,381.1	397,122.11
210102	Нэмэгдэл	4,929,613.2	4,992,887.2	-63,273.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,036,386.1	1,010,973.0	25,413.14
210104	Урамшуулал	195,503.9	630,281.7	-434,777.79
210105	Гэрээт ажлын хөлс	928,754.0	413,834.3	514,919.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,869,806.9	1,813,644.3	56,162.64
210201	Тэтгэврийн даатгал	1,194,549.4	1,166,290.0	28,259.44
210202	Тэтгэмжийн даатгал	152,857.0	142,442.0	10,415.01

210203	ҮОМШӨ-ний даатгал	204,420.3	202,810.5	1,609.81
210204	Ажилгүйдлийн даатгал	28,788.1	27,428.8	1,359.32
210205	Эрүүл мэндийн даатгал	289,192.1	274,673.0	14,519.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,582,065.7	4,275,737.1	1,306,328.57
210301	Гэрэл, цахилгаан	1,321,284.4	984,943.7	336,340.68
210302	Түлш, халаалт	2,507,358.7	2,251,429.3	255,929.43
210303	Цэвэр, бохир ус	1,588,375.0	864,398.7	723,976.27
210304	Байрны түрээс	165,047.6	174,965.4	-9,917.81
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,714,949.8	2,447,307.9	267,641.88
210401	Бичиг хэрэг	227,117.7	211,894.5	15,223.23
210402	Тээвэр, шатахуун	2,044,957.0	1,856,014.7	188,942.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	114,945.0	89,920.2	25,024.83
210404	Ном, хэвлэл	10,922.0	10,400.0	522.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	194,856.3	159,431.9	35,424.43
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,151.8	119,646.7	2,505.14
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	167,636.5	164,732.8	2,903.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.0	0.0	0.00
210502	Хоол, хүнс	51,981.5	51,618.6	362.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	115,655.0	113,114.3	2,540.71
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,396,006.8	2,264,993.5	131,013.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	331,633.5	327,128.5	4,505.04
210602	Тавилга	98,266.5	77,894.4	20,372.08
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	115,104.9	94,019.3	21,085.61
210604	Урсгал засвар	1,851,001.9	1,765,951.3	85,050.57
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	233,631.4	190,885.0	42,746.44
210701	Гадаад албан томилолт	56,000.0	41,048.6	14,951.43
210702	Дотоод албан томилолт	177,631.4	149,836.4	27,795.01
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	0.0	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,234,105.0	18,671,869.6	4,562,235.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,970,374.1	15,458,816.2	4,511,557.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	23,475.6	7,826.6	15,649.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,585.1	36,659.2	3,925.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	12,563.9	9,486.1	3,077.79
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,528.0	779.0	2,749.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	97,283.2	90,398.4	6,884.80
210807	Газрын төлбөр	128,521.0	111,618.1	16,902.92
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,953,354.1	2,951,876.1	1,478.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,420.0	4,410.0	10.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,550,854.2	1,221,281.4	329,572.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,501,087.9	1,174,464.0	326,623.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,766.3	46,817.4	2,948.90
<b>212</b>	<b>ТАТААС</b>	1,600,000.0	1,217,712.2	382,287.79
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	1,600,000.0	1,217,712.2	382,287.79
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,600,000.0	1,217,712.2	382,287.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	165,983,551.4	165,772,752.9	210,798.52
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	164,817,312.9	164,812,304.3	5,008.57
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	164,817,312.9	164,812,304.3	5,008.57
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.0	0.0	0.00

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,166,238.5	960,448.5	205,789.95
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	137,980.0	130,670.8	7,309.20
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000.0	6,098.6	3,901.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,968.8	142,603.3	4,365.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	521,677.2	386,915.8	134,761.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	349,612.5	294,160.1	55,452.42
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	86,340,563.4	59,646,159.7	26,694,403.66
220001	Барилга байгууламж	60,757,641.7	39,434,476.3	21,323,165.36
221001	Их засвар	6,723,800.1	6,687,200.9	36,599.21
222001	Тоног төхөөрөмж	14,753,733.2	10,187,619.9	4,566,113.31
223001	Бусад хөрөнгө	4,105,388.4	3,336,862.6	768,525.78
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	626,820.2	513,400.0	113,420.20
230001	Эргэж төлөгдөх зээл	626,820.2	513,400.0	113,420.20
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	307,911,751.7	276,972,884.3	30,938,867.45
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	16,970,445.9	16,782,273.3	188,172.64
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	16,970,445.9	16,782,273.3	188,172.64
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	256,533,474.2	256,077,971.4	455,502.82
320001	Орон нутгийн төсвөөс	256,533,474.2	256,077,971.4	455,502.82
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	31,607,831.6	1,512,639.6	30,095,191.98
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,571,996.2	1,511,436.6	2,060,559.58
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	1,203.0	-1,203.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,035,835.4	0.0	28,035,835.40
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.0	0.0	0.00
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	2,800,000.0	2,600,000.0	200,000.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,800,000.0	2,600,000.0	200,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,415,818.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	9,015,869.2	

#### 1.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,725,429,204.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,725,429,204.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,221,612,330.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>225,755,115.23</b>
210101	Үндсэн цалин	126,064,915.71
210102	Нэмэгдэл	37,729,163.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	464,000.00
210104	Урамшуулал	437,480.00
210105	Гэрээт ажлын хөлс	61,059,556.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,681,598.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,216,103.66

210202	Тэтгэмжийн даатгал	534,327.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	427,461.65
210204	Ажилгүйдлийн даатгал	45,792.42
210205	Эрүүл мэндийн даатгал	457,914.16
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>864,000.00</b>
210304	Байрны түрээс	864,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>412,144,375.97</b>
210401	Бичиг хэрэг	58,119,800.00
210402	Тээвэр, шатахуун	340,698,282.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,155,606.97
210404	Ном, хэвлэл	3,934,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,236,687.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,695,000.00</b>
210502	Хоол, хүнс	19,895,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>472,707,523.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	256,920,400.00
210602	Тавилга	7,650,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,535,500.00
210604	Урсгал засвар	204,601,623.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,555,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,555,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,002,476,117.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	998,384,117.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,092,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,733,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,733,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,503,816,874.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>337,040,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	280,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,540,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,166,776,874.45</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	165,119,286.45
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,001,657,588.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,725,429,204.64</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,725,429,204.64</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,092,494,219.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	381,981,643.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,250,953,342.64

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн багцад нэгтгэгддэг төсвийн төвлөрүүлэн захирагч 1, орон нутгийн өмчит 7 байгууллага, төсвийн шууд захирагч 24 байгууллага нийт 32 байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэснээс 11 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 21 байгууллагад бие дааж дүгнэлт гаргасан.

Санхүүгийн тайлангийн аудитаар 45.2 сая төгрөгийн 38 төлбөрийн акт тогтоож, 1,217.1 сая төгрөгийн 30 албан шаардлага, 779.8 сая төгрөгийн 75 зөвлөмжийг хүргүүлж, 2,135.1 сая төгрөгийн 44 алдааг аудитын явцад залруулж, 17 байгууллагад “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, 3 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Засаг даргын 2023 оны нэгтгэсэн тайлангийн багцад хамааралтай байгууллагын алдаа зөрчлийг хүснэгтээр үзвэл: /сая төгрөг/

Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн ангилал											
	акт		албан шаардлага		зөвлөмж		хариуцлага тооцох санал		залруулсан алдаа		Нийт алдаа зөрчил	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ</b>												
Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	-	-	1	6.96	2	50.02	-	-	-	-	3	56.98
<b>ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ</b>												
Их шүтээн цогцолбор ААТҮГ	1	0.14	3	5.00	2	-	-	-	-	-	6	5.14
Гэр бүлийн ордон ААТҮГ	1	0.16	-	-	2	0.64	-	-	-	-	3	0.79
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ААТҮГ	2	8.00	3	93.97	1	-	-	-	-	-	6	101.97
Хот байгуулалт барилга захиалагчийн алба ААТҮГ	4	4.05	4	21.45	6	66.10	1	-	2	416.03	17	507.64
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	7	6.10	-	-	5	-	-	-	3	22.81	15	28.91
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа ААТҮГ	1	1.13	-	-	1	-	-	-	4	2.23	6	3.36
Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	2	1.80	1	-	4	202.49	-	-	-	-	7	204.29
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>												
Эрдэнэт хотын захирагчийн алба	3	2.12	-	-	6	-	-	-	1	3.84	10	5.95
Мэдээлэл шуурхай удирдлагын төв	-	-	-	-	1	0.42	-	-	3	0.00	4	0.42
цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	1	0.56	-	-	1	-	-	-	1	0.25	3	0.81
Хот тохижуулах газар	1	1.00	4	281.38	5	9.28	1	-	3	874.33	14	1,165.98

Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	3.48	-	-	1	0.40	-	-	-	-	2	3.88
Жаргалант сумын ИТХ	2	1.99	-	-	3	3.44	-	-	-	-	5	5.43
Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	2	6.85	1	-	3	22.21	-	-	-	-	6	29.06
Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан	-	-	-	-	1	6.27	-	-	-	-	1	6.27
Баян-Өндөр сумын ЗДТГ	3	2.64	1	335.49	4	68.04	-	-	7	-	15	406.17
Баян-Өндөр сумын ИТХ	-	-	1	0.28	2	15.53	-	-	6	73.12	9	88.93
Баян-Өндөр сумын ОНХСан	-	-	1	364.06	-	-	-	-	-	-	1	364.06
Баян-Өндөр сумын ХХСан	-	-	-	-	3	183.51	-	-	2	7.96	5	191.46
Аймгийн ИТХ	3	4.03	1	36.06	3	14.51	-	-	1	43.96	8	98.56
Орон нутгийн өмчийн газар	-	-	1	1.00	2	0.16	-	-	-	-	3	1.16
аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт аудитын алба	1	0.53	1	1.87	2	0.47	-	-	-	-	4	2.86
Аймгийн ЗДТГ	-	-	2	31.00	3	67.50	-	-	2	202.65	7	301.15
Орон нутгийн хөгжлийн сан	-	-	1	11.00	-	-	-	-	1	23.00	2	34.00
Орон нутгийн хөрөнгө оруулалт	-	-	-	-	1	8.50	-	-	-	-	1	8.50
Төсөл хөтөлбөр	-	-	-	-	2	-	-	-	1	400.02	3	3,351.89
Авто замын сан	-	-	-	-	1	-	-	-	-	-	1	-
Эрдэнэт сан	-	-	1	10.49	1	-	-	-	-	-	2	10.49
Нийтлэг үйлчилгээний алба	-	-	1	8.03	3	28.32	-	-	-	-	4	36.35
Сум дундын ойн анги	1	0.03	1	1.36	3	31.68	-	-	-	-	5	33.08
Байгаль орчин аялал жуулчлалын газар	2	0.57	1	7.70	1	0.37	-	-	7	64.91	11	73.54
<b>Нийт дүн</b>	<b>38</b>	<b>45.2</b>	<b>30</b>	<b>1,217.1</b>	<b>75</b>	<b>779.8</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>44</b>	<b>2,135.1</b>	<b>189</b>	<b>4,177.2</b>

Аймгийн Засаг даргын багцад хамааралтай 32 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,042.1 сая төгрөгийн 145 алдаа зөрчил илэрснийг өмнөх онтой харьцуулахад зөрчлийн тоо хэмжээ 163-аас 145 болж 11 хувиар буурсан бол зөрчлийн мөнгөн дүн 3,615.1 сая төгрөгөөс 1,573.0 сая төгрөг буюу 56 хувиар буурч 2,042.1 сая төгрөг болжээ.

### **Орхон аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан:**

Аудитаар нийт 33.25 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 33.25 сая төгрөгийн алдааг залрууллаа.

**Залруулсан алдаа:** Эрдэнэт Ус ДТС ОНӨХК нь санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайланд 33.25 сая төгрөгийн дахин үнэлгээний бууралтыг буруу тайлагнасныг аудитын явцад залруулан бүртгэлээ.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 277.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлж, 274.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн 32 байгууллагын санхүүгийн тайлангийн зөрчил 2,042.1 сая, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зөрчил 274.7 сая, нийт 2,319.6 сая төгрөгийн зөрчил нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 3,541.7 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70% буюу 2,479.2 сая төгрөгөөр тогтоосноос хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

### **5.1 Төлбөрийн акт**

Аймгийн ИТХ-ын даргад гадаад албан томилолтын зардлын 2.8 сая төгрөгийг 2 өөр байгууллагын төсвөөс давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

Өмнөх онд хийгдсэн аудитаар “Эрдэнэт сангийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох хэлтсийг үр дүнтэй ажиллуулж, хариуцлагыг сайжруулах”, “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлж буй усны алдагдал бодитой эсэхийг тогтоож дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд анхаарч, төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах” гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулаагүй, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байх тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын Б/09 дүгээр захирамжаар Эрдэнэт Хотын захирагчийн албаны даргын албан тушаалын цалинг Төрийн захиргааны албан тушаалын ТЗ-4 зэрэглэлээр цалинжуулсан байна. Энэ нь Засгийн газрын “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны 487 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хотын захирагчийн албаны төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, тохирох төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлээр цалинжуулах.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас БНХАУ, БНСУ, Польш, Чех зэрэг гадаадын улсад туршлага судлах, хурал зөвлөгөөнд оролцоход нийт 268.7 сая төгрөгийг зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, явсан эсэх нь тодорхойгүй, хурал зөвлөгөөнөөс гарсан үр дүн тодорхойгүй байна.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”; 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.6-д “сахилга баттай байх”, 4.1.3-т “үр ашигтай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гадаад томилолтын хөтөлбөр, төлөвлөгөө, үр дүнг бодитоор урьдчилан тооцож арвилан хэмнэлттэй зарцуулан, үр ашгийг дээшлүүлэх, анхан шатны баримтын бүрдэлд онцгой анхаарах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Үндэсний аудитын газарт санал:**

Монгол улсын Ерөнхий сайд 2023 оны 09 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Орхон аймагт ажиллахтай холбоотойгоор ирсэн төлөөлөгч нарын буудал, хоолны зардалд орон нутгийн төсвөөс Засаг даргын А/748, А/749, А/750, А/751, А/752, А/772 захирамжаар 35.4 сая төгрөгийг зарцуулсан нь яам агентлагийн албан томилолтын зардалтай давхцах эрсдэлтэй байна.

Өмнөх оны төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлаас 25 төрийн болон төрийн бус байгууллагын 200 гаруй ажилтны цалингийн санхүүжилтэд 2,498.0 сая төгрөгийг олгосон, тэмдэглэлт баяр ёслол, хүлээн авалтын хоол, сургалтын цай, хоол, бичиг хэргийн зардлыг санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч тайлант онд төсөл хөтөлбөрийн зардлаас 217 ажилтны 1,369.6 сая төгрөгийн цалин, 6 төрийн бус байгууллагын 41 ажилтны цалинд 261.5 сая төгрөг нийт 1,631.1 сая төгрөгийг олгож, гадаадын зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 96.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан зөрчил арилахгүй давтагдсаар байх тул Засгийн газрын нэгтгэсэн тайланд тусгуулж арга хэмжээ авах саналыг хүргүүлж байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-нь санхүүгийн өмчийн өөрчлөлтийн тайланд 33.25 сая төгрөгийн дахин үнэлгээний бууралтыг буруу тайлагнасныг аудитын явцад залруулан бүртгэлээ.	1	33.25			1	33.25	1	33.25				
Дүн	1	33.25	1	33.25	1	33.25	1	33.25				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Гадаад албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	2.8	1	2.8								
Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулаагүйгээс илүү цалин олгосон.	1						1	6.0				
гадаадын улсад туршлага судлах, хурал зөвлөгөөнд оролцоход нийт 268.7 сая төгрөгийг зарцуулсан боловч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, явсан эсэх нь тодорхойгүй, хурал зөвлөгөөнөөс гарсан үр дүн тодорхойгүй.	1	268.7					1	268.7				
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй.	2				2							
Дүн	5	277.5	1	2.8	2		2	274.7				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал





ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 130/АМН/0338

Эрдэнэт хот

ОРА-2024/01/УАА-СТА-ТЭЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулсан "Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг тусгаж хэрэгжүүлэх нь" сургалтын гадаад албан томилолтын зардлыг Онцгой байдлын комисс болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс 2,754,600 төгрөгийг давхар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно", Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээ" хэсгийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь.**

1. Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал нь давхар олгосон томилолтын зардал 2,754,600 (Хоёр сая долоон зуун тавин дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга (Д.Мөнхбат), аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Нарын бичгийн дарга (Б.Ганзориг), нягтлан бодогч (Э.Халиун) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:.....О.ГАНТУЯА

АУДИТОР:.....Г.ДАВААСҮРЭН

<sup>1</sup> Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 98/А/Н#0338

Эрдэнэт

ОРА-2024/01/НА-СТА-ТЭС

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Эрдэнэт сангийн авлага болох 23.3 сая төгрөгийг Орхон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн дансанд төвлөрүүлснийг Орхон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын өр төлбөрт суутган шилжүүлж, гэм буруутай этгээдээр төлүүлээгүйд "Хуулийн байгууллагад шилжүүлсэн авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох хэлтсийг үр дүнтэй ажиллуулж, хариуцлагыг сайжруулах" гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлт хангагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн дансанд төвлөрсөн 23.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж,

биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Засаг даргын орлогч (М.Түмэнжаргал), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар хорих ангийн дарга дэд хурандаа (Р.Ууганбаяр), Эрдэнэт сан хариуцсан мэргэжилтэн (П.Энхжаргал) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР: ..... Т.БОЛОРМАА

<sup>1</sup> Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 99/А1440338

ОРА-2024/01/НА-СТА-ТЭС

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн өр төлбөр жил бүр өссөн талаар хүчин зүйлийн судалгаа хийдэггүй, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлсэн усны тооцоо, алдагдлыг бууруулах талаар үр нөлөөтэй ажил зохион байгуулаагүй зөрчилд “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлж буй усны алдагдал бодитой эсэхийг тогтоох болон дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд анхаарч, төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах” гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.12-т “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй бөгөөд аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлж буй усны алдагдлыг бодитой эсэхийг тогтоож, төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулаагүй зөрчлийг арилгаж,

биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Засаг даргын орлогч (М.Түмэнжаргал), Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн захирал (Д.Бүүвэйбаатар), аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (С.Даваадорж) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР:..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР:..... Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР:..... Т.БОЛОРМАА

<sup>1</sup> Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812